

ТАНАЙ СУМЫГ ЗОРИН ИРЭХ ИРГЭДЭД ЯМАР БОЛОМЖ НӨХЦӨЛ ОЛГОХ ВЭ?

Амьдрах өмчлөлийн, үйл ажиллагаа эрхлэх эзэмшлийн газар олгох

Төмс хүнсний ногоо болон жимс, жимсгэнэ тариалах газар олгох

Суманд шилжин ирж төрийн албан хаагчаар ажилласан тохиолдолд амьдрах байр, орон сууцаар ханган ажиллана. Манай суманд аймгийн хөрөнгө оруулалтаар төрийн албан хаагчдын 600 м2 орон сууц худалдан авах ажил 2023 онд амжилттай зохион байгуулагдсан.

Бизнес эрхлэхээр гаргасан саналыг дэмжин төсөл хөтөлбөрт хамруулж, хөнгөлөлттэй зээл олгох бүрэн боломжтой.

Эрчимжсэн үхрийн аж ахуй эрхлэх тал дээр дэмжиж, хамтарч ажиллах

Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

Төрийн албан хаагчийн үндсэн цалин, Сэлэнгэ аймагт ажилласны 50% нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, ажил хавсран гүйцэтгэсны нэмэгдэл, төрийн үйлчилгээний ажилтны ур чадварын нэмэгдэл, 13 дахь сарын цалин, улирлын урамшууллыг олгодог.



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ:

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум нь МЭӨ III - МЭ I зууны үед Монгол нутагт оршин тогтнож байсан Умард Хүннү, МЭ IV - МЭ VI зууны үед Жужан гүрний төв хэсэг байсан бөгөөд түүнээс үед Өгөөдэйн улсын зүүн хязгаар нутаг, Манж улсын үед Халхын Ахай бэйсийн хошуу, Богд хаант Монгол Улсын үед Түшээт хан аймгийн Ахай гүний хошуу, 1921-1931 онд Богд хан уул аймгийн Булган ширээ уулын хошуу, 1931 онд Сэлэнгэ аймаг байгуулагдахад Орхонтуул сум болжээ.



80804441



<http://orkhontuul.se.gov.mn/>



Орхонтуул сум нь 2940.8 км² газар нутагтай, засаг захиргааны 3 багтай, 1099 өрхтэй, 3930 хүн амтай, 26.900 га тариалангийн талбайтай 255054 мянган толгой малтай. Сумын төв нь Баянцогт 2-р багт байрладаг.

Улаанбаатар хотоос 332 км, Дархан хотоос 135 км, Эрдэнэт хотоос 100 км зайд оршдог нь хүн ам олноор суурьшсан хөгжиж буй хотуудтай ойролцоо, бүх төрлийн худалдаа, үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжтой.

Сумын газар нутгийн 95.1 хувь нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар эзэлдэг. Үүнээс газар тариалангийн талбай 27373 га, жимс жимсгэнэ 15 га, хадлангийн талбай 12000 га, бэлчээрийн талбай 262126 га талбайг тус тус эзэлдэг нь газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх давуу талтай.



Орхонтуул сум нь 1982 оноос хойш Сэлэнгэ үүлдрийн улаан халзан үхэр өсгөн үржүүлж ирсэн. Одоогийн байдлаар “Сэлэнгэ” үүлдрийн үхэр нь нийт үхэр сүргийн 75 хувийг эзлэж байгаа цаашид эрчимжсэн үхрийн аж ахуй хөгжүүлэх томоохон бааз суурь болж байна.

Орхонтуул сум нь эрчимжсэн мал аж ахуйн газар тариалангийн бүсэд хамаарагддаг.

Орхонтуул сумын хөгжих боломж:

- Эрчимжсэн мал аж ахуй
- Газар тариалан
 - Төмс хүнсний ногоо
 - Жимс жимсгэнэ
- Хадлан тэжээл бэлтгэх
- Хөнгөн үйлдвэрлэл



ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БҮЙ БОЛОН ХИЙХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖИЛ, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛ:

Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж ажиллана.

Улаанбаатар хотоос Орхонтуул суманд шилжин суурьшиж бизнес эрхлэхээр ирсэн иргэдийг бодлогоор дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах шаардлагатай өмчлөл эзэмшлийн газрыг шийдвэрлэх

